



## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/106

Улаанбаатар хот

### Бакалаврын өдрийн хөтөлбөрт 2022 онд оюутан элсүүлэх журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 11.3, 12.1.6, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам"-ын 1.2, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/47 дугаар "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/138 дугаар "Босго оноо тогтоох тухай" тушаал, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 4.3.8.8, 6.4 дэх заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Их Сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2022 онд оюутан элсүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаал гарсантай холбогдуулан элсэлтийн бодлого, журам сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулахыг Элсэлт, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Хишигням), Мэдээллийн технологийн газрын дарга (А.Баатарбилэг) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Журмын дагуу элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахыг Элсэлт, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Хишигням), Мэдээллийн технологийн газрын дарга (А.Баатарбилэг), бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирал (Д.Заяабаатар, Д.Бямбажав, Ч.Энхбаяр, Б.Амарсанаа, С.Баттулга, Д.Алтанхуяг, Т.Энх-Амгалан) нарт тус тус даалгасугай.
4. Элсэлтийн үйл ажиллагааны явц, үр дүн, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал (Д.Бадмаанямбуу)-д үүрэг болгосугай.
5. Захирлын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/90 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Их Сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2021 онд оюутан элсүүлэх журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

1422061401

Захирлын 2022 оны ..... дугаар сарын .....-ны  
өдрийн ..... дугаар тушаалын хавсралт



## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ 2022 ОНД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

### НЭГ. Ерөнхий зүйл

1.1 Монгол Улсын Их сургууль (цаашид МУИС гэнэ)-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2022 онд оюутан элсүүлэхэд Монгол Улсын "Дээд боловсролын тухай хууль", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 03 дугаар сарын 18-ны А/79 тоот тушаалаар баталсан "Оюутан элсүүлэх журам", Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/194 тоот "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/47 дугаар "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/138 тоот "Босго оноо тогтоох тухай" тушаал бусад холбогдох эрх зүйн акт болон энэхүү журам (цаашид журам гэнэ)-ыг баримтална.

1.2 МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг "бүртгүүлэгч", элсүүлэх оюутны тоог "хяналтын тоо", хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн цахим бүртгэлийн системийг "элсэлтийн систем", элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг "элсэлтийн комисс" гэнэ.

1.3 МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт Улаанбаатар хот болон орон нутгаас элсүүлэх элсэгчийн хяналтын тоог Удирдах зөвлөл тогтооно.

1.4 Элсэлтийн журам, бүрэлдэхүүн сургуульд элсэх хөтөлбөр, элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын оноо тооцох болон холбогдох бусад мэдээллийг <https://burtgel.num.edu.mn> элсэлтийн системд байршуулна.

1.5 МУИС-д гадаадын харьяат иргэнийг элсүүлэх асуудлыг "МУИС-д гадаадын иргэнийг суралцуулах журам"-аар зохицуулна.

### ХОЁР. Элсэлтийн комисс

2.1 МУИС-ийн элсэлтийн комиссын дарга нь Сургалт, оюутан хариуцсан дэд захирал, нарийн бичгийн дарга нь Элсэлт, бүртгэлийн хэлтсийн дарга, гишүүд нь Мэдээллийн технологийн газрын дарга, Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал, Санхүү, төлөвлөлтийн газрын дарга, Элсэлт, бүртгэлийн хэлтсийн элсэлт хариуцсан мэргэжилтнүүд байх ба МУИС-ийн захирлын тушаалаар томилно.

2.2 Комиссын дарга элсэлтийн ажлыг удирдлагаар хангаж, тухайн журмаар зохицуулагдахгүй асуудлыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн саналыг үндэслэн комиссын хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

2.3 Элсэлтийн комисс нь хяналтын тоо үлдсэн тохиолдолд нэмэлт элсэлт зохион байгуулж болно.

## ГУРАВ. Бүртгүүлэгчдэд тавих шаардлага

3.1 МУИС-д элсэхийг хүссэн иргэд энэхүү журамтай танилцаж, элсэлтийн системд бүртгүүлнэ.

3.2 Бүртгүүлэгч нь Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-өөс зохион байгуулдаг элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ) өгсөн харьяалагдах бүсэд өрсөлдөнө. Бүсийг тогтоохдоо УИХ-ийн 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” бодлогын хүрээнд заасан дараах бүсчлэлийг баримтална. Үүнд: Зүүн бүсэд Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Говийн бүсэд Төв<sup>1</sup>, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Алтайн бүсэд Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Баруун бүсэд Ховд, Баян-Өлгий, Увс, Хангайн бүсэд Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Архангай, Хөвсгөл, Завхан аймаг, Төвийн бүсэд Улаанбаатар хот хамаарна.

3.3 Бүртгүүлэгч нь МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль (ШУС), Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль (ХШУИС), Бизнесийн сургууль (БС), Хууль зүйн сургууль (ХЗС), Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль (ОУХНУС), Эрдэнэт сургууль (ЭС), Завхан сургууль (ЗС)-ийн сургуулийн багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрөөс сонгоно. Бүртгүүлэгч өөрийн хүсэлтээр хэдэн ч бүрэлдэхүүн сургууль/салбар сургуулийн багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрт бүртгүүлж болно.

3.4 Бүртгүүлэгч нь Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-ийн хүчинтэй батламжтай, эсвэл 2022 онд ЭЕШ өгөхөөр БҮТ-д бүртгүүлсэн байна. Бүртгүүлэгч нь МУИС-ийн окутан бол бүртгүүлэх боломжгүй.

3.5 Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн Монгол улсын иргэн БШУЯ-ны сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны А/347 тоот тушаалаар баталсан "Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол Улсын элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээтэй дүйцүүлэх журам"-ыг баримтална.

## ДӨРӨВ. Элсэх хүсэлт гаргах

4.1 МУИС-д элсэхийг хүссэн иргэд орон даяар, цахим хэлбэрээр <https://burtgel.num.edu.mn> хаягийн бакалаврын өдрийн элсэлтийн системээр бүртгүүлнэ.

4.2 Бүртгэлийг 2022 онь 06 дугаар сарын 02-ны өдрийн 09:00 цагт нээж, ЭЕШ дууссан өдрийн дараагийн өдрийн 12:00 цагт хаана.

4.3 Бүртгүүлэгч нь элсэлтийн системд БҮТ-ийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан нэвтэрнэ (ЭЕШ-ыг 2 удаа өгсөн бол бүртгэл тус бүрээр хүсэлт гаргаж бүртгүүлнэ). Системд шаардлагатай мэдээллээ үнэн зөв оруулан баталгаажуулна.

4.4 Бүртгүүлэгч нь элсэлтийн системд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг өөрөө хариуцах ба алдаатай, буруу мэдээлэл оруулснаас үүсэх асуудлыг МУИС хариуцахгүй.

4.5 Элсэлтийн системд нэвтрэх эрхтэй болсны дараа элсэх хүсэлт гаргах бүрэлдэхүүн сургууль/салбар сургуулийн багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрөөс

<sup>1</sup> Төв аймаг Төвийн бүсэд хамаарах боловч Улаанбаатар хотын төгсөгчийн тоо, чанараас шалтгаалан Говийн бүсэд багтаасан болно.

(журмын хүснэгт 1-ээс үзнэ) сонгон бүртгэлийн хураамжийг цахим хэлбэрээр төлж баталгаажуулна. (Төлбөр төлөх тухай дэлгэрэнгүй зөвлөмжийг элсэлтийн системээс үзнэ үү).

4.6 Бүртгэлийн хураамжийг нэг удаа төлж хэдэн ч бүрэлдэхүүн/салбар сургуулийн багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрт бүртгүүлэх боломжтой (ЭЕШ-ыг 2 удаа өгсөн бол бүртгэл тус бүрээр хүсэлт гаргаж бүртгэл тус бүрээр бүртгэлийн хураамж төлнө). Бүртгэлийн хураамжийг Удирдах зөвлөлөөс баталсан "Үйлчилгээний бусад хураамжийн хэмжээ"-д заасны дагуу авна. Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

### **ТАВ. Элсэгчийг шалгаруулах**

5.1 Элсэлтийн бүртгэл хааснаас 1 өдрийн дараа системд бүртгүүлэгчийн ЭЕШ-ын дүн, мэдээллийг БҮТ-өөс татан авч, холбогдох тооцооллыг хийн онооны жагсаалтыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрөөр гаргана.

5.2 Бүртгүүлэгчийн оноог дараах байдлаар тооцно. "Суурь" шалгалтад тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.7, "Дагалдах" шалгалтад тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.3-аар үржүүлж нэмсэн нийлбэрээр тооцоолсон оноог бодно. Бүрэлдэхүүн сургууль/салбар сургуулийн багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрийн тооцоолсон онооны босгыг журмын хүснэгт 1-д заасныг баримтална. Завхан сургууль, Эрдэнэт сургуулийн хувьд БШУЯ-аас баталсан их, дээд сургуульд элсэгчдийн хангасан байх босго онооноос багагүй байна.

5.3 Оноо тэнцсэн тохиолдолд ЭЕШ-ын гүйцэтгэлийн хувийг тооцон байр эзлүүлж, элсэх эрх олгох ба гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог харгалзана. ЭЕШ-ын гүйцэтгэлийн хувийг тооцохдоо 5.2-т заасан аргачлалын дагуу тооцно.

5.4 Тооцох "Суурь" болон "Дагалдах" шалгалтын оноо МУИС-ийн Улаанбаатар дахь бүрэлдэхүүн сургуулийн хувьд тус бүр 480 онооноос багагүй, Завхан сургууль, Эрдэнэт сургуулийн хувьд БШУЯ-аас баталсан их, дээд сургуульд элсэгчдийн хангасан байх босго онооноос багагүй байна. Суурь шалгалтад тооцуулсан хичээлийн оноог дагалдах шалгалтад давхар тооцуулахгүй.

5.5 Бүртгүүлэгч нь бүрэлдэхүүн сургууль/салбар сургуулийн багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрт харгалзах тооцоолсон онооны босгыг хангасан, ЭЕШ-ын суурь шалгалтад тооцох хичээлээр сүүлийн 2 жилийн дотор дараах шаардлагыг хангасан тохиолдолд шилдэг элсэгч гэж үзэн олимпиад, англи хэлний олон улсын шалгалт, Кембриж, IB-ийн олон улсын шалгалт, спортын тэмцээн зохион байгуулах комиссоос олгосон батламж, сертификат болон баримт бичигт үндэслэн хяналтын тоонд багтаан элсүүлнэ. Үүнд:

5.5.1 Олон улс, улсын олимпиад нөхцөлийг хангасан ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчийг тухайн чиглэлээр шууд элсүүлнэ.

5.5.1.1 БШУЯ-аас тогтоосон Олон улсын олимпиадад оролцож 1-ээс 3-р байр эзэлсэн, журмын хүснэгт 2-т заасан нөхцөлийг хангасан байна.

5.5.1.2 Улсын олимпиадад оролцож 1-ээс 3-р байр эзэлсэн (Улсын зарим олимпиад нэг байрт олон оролцогч шалгаруулдаг тул

онооны жагсаалтаар зөвхөн эхний 1-6-д орсон 6 оролцогчийг элсүүлнэ) оролцогч журмын хүснэгт 2-т заасан нөхцөлийг хангасан байна.

- 5.5.2 Англи хэлний олон улсын шалгалтын IELTS 5, TOEFL iBT 35, TOEFL PBT 500, TOEIC 685-аас дээш оноотой бүртгүүлэгчдийг гүйцэтгэлийн хувиар жагсаан<sup>2</sup>, эхний 3 байр эзэлсэн бүртгүүлэгчийг ШУС-ийн Багц 2-т шууд элсүүлнэ.
- 5.5.3 Кембрижийн олон улсын AS (A) түвшний шалгалтын b (B) -ээс дээш, IB (international baccalaureate) хөтөлбөрийн 4-өөс дээш үнэлгээтэй бүртгүүлэгчдийг сургууль бүрд суурь шалгалтад тооцохоор заасан хичээлээр нь онооны дарааллаар жагсаан, эхний 3 байр эзэлсэн бүртгүүлэгчийг шууд элсүүлнэ.
- 5.5.4 Спортын өндөр ур чадвартай бүртгүүлэгчдээс комисс 5 хүртэлх бүртгүүлэгчийг шалгаруулан ШУС, ХШУИС-ийн багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрийн харгалзах тооцоолсон онооны босгыг хангасан тохиолдолд гэрээ байгуулж элсүүлж болно (Олимп, тив, дэлхийн тэмцээнээс медальт болон шагналт байранд шалгарсан, улсын өсвөр үеийн, улсын идэрчүүдийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байранд шалгарсан).

5.6 Шилдэг элсэгч нь тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрт харгалзах суурь болон дагалдах шалгалтад тооцохоор заасан хичээлүүдээс ЭЕШ өгсөн байх ба харгалзах тооцоолсон онооны босгыг хангасан байна.

5.7 МУИС-ийн Байгаль эх лицей сургуулийн төгсөгчийг тухайн бүрэлдэхүүн/салбарын багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрт харгалзах суурь болон дагалдах шалгалтад тооцохоор заасан хичээлүүдээс ЭЕШ өгч, харгалзах тооцоолсон онооны босгыг хангасан бол ШУС, ХШУИС-ийн багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрт шууд элсүүлнэ.

5.8 5.5-5.7 дахь нөхцөлийг хангасан бүртгүүлэгч “Олимпиад”, “Англи хэлний олон улсын шалгалт”, “Кембриж, IB-ийн олон улсын шалгалт”, “Спортын ур чадвар”, “Байгаль эх лицей” гэсэн ангиллаас сонгон бүртгүүлж, журмын 4.5-д заасан бүртгэлийн хураамж төлж, тухайн нөхцөл хангасныг гэрчлэх бичиг баримтын эх хувийг сканердан, өргөдлийн хамт бүртгэлийн хугацаа хаахаас 7 хоногийн өмнө Элсэлт, бүртгэлийн хэлтсийн [elselt@num.edu.mn](mailto:elselt@num.edu.mn) цахим шуудан руу илгээж бүртгүүлнэ.

### **ЗУРГАА. Элсэх эрх олгох**

6.1 Элсэх эрх олгох үйл ажиллагааг орон даяар цахим хэлбэрээр <https://burtgel.num.edu.mn> хаягийн бакалаврын өдрийн элсэлтийн системээр явуулна.

6.2 Бүртгүүлэгч хяналтын тоонд багтсан эсэхээ онооны жагсаалт гарсны дараа элсэлтийн системд нэвтэрч шалгана.

6.3 Шилдэг элсэгч ангиллын шалгаруулалтад тэнцсэн болон “Байгаль эх лицей” сургуулийг төгссөн бүртгүүлэгч нь элсэн суралцах бүрэлдэхүүн/салбар

<sup>2</sup> Шалгалт бүрийн хамгийн дээд оноог 100 хувь гэж үзэн авсан оноог хувьд шилжүүлснээр гүйцэтгэлийн хувь гарна.

сургуулийн ерөнхий суурь хөтөлбөрийн 1 багц цагийн төлбөрийг төлж элсэх эрхээ баталгаажуулна.

6.4 Элсэх эрх олгох үйл ажиллагааг 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийг дуустал зохион байгуулна.

6.5 Хэд хэдэн бүрэлдэхүүн/салбар сургуулийн хяналтын тоонд багтсан элсэгч нь зөвхөн нэг бүрэлдэхүүн/салбар сургуулийн багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрөөс сонгох ба бусад бүрэлдэхүүн/салбар сургуулийн хяналтын тооны жагсаалтаас нэр нь хасагдаж босго шугам нэгээр доошилно. Босго шугам доошилсны дүнд хяналтын тоонд багтсан дараагийн бүртгүүлэгчид элсэх эрх үүснэ.

6.6 Бүртгүүлэгч хяналтын тоонд багтаж элсэх эрхтэй болсноос хойш 4<sup>3</sup> цагийн дотор элсэх эрхээ баталгаажуулна. Энэ хугацаанд баталгаажуулаагүй тохиолдолд МУИС-д элсэхээс татгалзсан гэж үзэн жагсаалтын дараах бүртгүүлэгчид элсэх эрхийг шилжүүлнэ.

6.7 Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч журмын 6.6-д заасан хугацаанд элсэлтийн системд нэвтэрч элсэн суралцах бүрэлдэхүүн/салбар сургуулийн ерөнхий суурь хөтөлбөрийн 1 багц цагийн төлбөрийг төлж элсэх эрхээ баталгаажуулна.

6.8 Элсэх эрхээ баталгаажуулсан төлбөрийг суралцагчийн сургалтын төлбөрт тооцно. Элсэх эрхээ цуцлах тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүй<sup>4</sup>.

#### **ДОЛОО. Элсэгчийг бүртгэх**

7.1 Элсэгч нь 2022 оны 08 дугаар сарын 10-ны 18:00 цаг хүртэл <https://burtgel.num.edu.mn> хаягийн бакалаврын өдрийн элсэлтийн системээр нэвтэрч маягт бөглөн, "МУИС-д суралцагч суралцуулах гэрээ"-г зөвшөөрсөн эсэхээ баталгаажуулж, цахим хэлбэрээр бүртгүүлэн оюутан болох хүсэлт илгээн оюутны дугаар, нууц үг авна.

7.2 Тус журмын 7.1-д заасан хугацаанд оюутан болж бүртгүүлээгүй тохиолдолд МУИС-д элсэхээс татгалзсан гэж үзнэ.

#### **НАЙМ. Элсэгчдэд олгох тэтгэлэг<sup>5</sup>**

8.1 БШУЯ-наас тогтоосон Олон улсын олимпиад болон улсын олимпиадад оролцож 1-ээс 3-р байрт шалгарсан элсэгчид сургалтын төлбөрийн 50-100 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно. Үүнд:

8.1.1 Олон улсын олимпиадад оролцож 1-ээс 3-р байр эзэлсэн элсэгчид 100 хувь;

8.1.2 Улсын олимпиадад оролцож 1-р байрт шалгарсан элсэгчид 100 хувь;

8.1.3 Улсын олимпиадад оролцож 2-р байрт шалгарсан элсэгчид 75 хувь;

8.1.4 Улсын олимпиадад оролцож 3-р байрт шалгарсан элсэгчид 50 хувь;

8.2 ЭЕШ-ын өндөр үнэлгээтэй элсэгчдэд сургалтын төлбөрийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно. Үүнд:

<sup>3</sup> Комиссын шийдвэрээр эрх баталгаажуулах хугацааг өөрчилж болно.

<sup>4</sup> Хуваарь буцааснаар дараагийн бүртгүүлэгч хуваарь авч чадахгүйд хүрч, эрх ашиг нь хөндөгддөг тул хариуцлагатай сонголт хийлгэх үүднээс урьдчилж төлүүлдэг.

<sup>5</sup> Тэтгэлэг олгох үйл ажиллагаа "МУИС-д тэтгэлэг олгох нийтлэг журам"-ын дагуу зохион байгуулагдана.

8.2.1 ЭЕШ-ын өндөр үнэлгээтэй элсэгчдэд сургалтын төлбөрийн 100 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно.

8.2.1.1 Суурь шалгалтад 700 буюу түүнээс дээш оноо авч ШУС-ийн Байгалийн ухааны хөтөлбөрүүд буюу ШУС-ийн Багц 3-д элссэн бол.

8.2.2 ЭЕШ-ын өндөр үнэлгээтэй элсэгчдэд сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно. Үүнд:

8.2.2.1 Суурь шалгалтад 650 буюу түүнээс дээш оноо авч ШУС-ийн Байгалийн ухааны хөтөлбөрүүд буюу ШУС-ийн Багц 3-т элссэн бол.

8.2.2.2 Суурь шалгалтад 750 буюу түүнээс дээш оноо авч ШУС, ХШУИС, Завхан сургууль, Эрдэнэт сургуульд элссэн бол.

8.2.2.3 Суурь шалгалтад 780 буюу түүнээс дээш оноо авч ХЗС, БС, ОУХНУС-д элссэн бол.

8.2.3 Цаашид суралцагч сурлагын амжилтаас шалтгаалан 50-100 хувийн тэтгэлгийг үргэлжлүүлэн авах боломжтой.

8.3 МУИС-ийн Байгаль эх лицей сургуулийн төгсөгч нь суурь шалгалтад 650 болон түүнээс дээш оноо авч ШУС-ийн Байгалийн ухааны салбар, ХШУИС-д элссэн бол сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно.

8.4 Олимпиад ангилал болон МУИС-ийн Байгаль эх лицей сургуулийн төгсөгч тус журмын 5.8-д заасны дагуу бүртгүүлснээр тэтгэлэгт хамрагдах боломжтой.

8.5 ХШУИС-ийн 2+2, 1+3 хөтөлбөрт элссэн элсэгчийг дэмжих бодлогоор сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно. Цаашид суралцагч сурлагын амжилтаас шалтгаалан тэтгэлгийг үргэлжлүүлэн авах боломжтой.

8.6 ШУС-ийн багшийн хөтөлбөр буюу ШУС-ийн багц 4, ЭС-ийн багц 2 дахь багшийн хөтөлбөрт элссэн элсэгч нь ЭЕШ-д 650-750 оноо авсан бол 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол 100 хувь сургалтын төлбөрийг төрөөс эхний улиралд төлнө. Цаашид суралцагч сурлагын голч дүн 3.0 болон түүнээс дээш оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн 100 хувь олгоно.

8.7 Орон нутгийн салбар сургуулиуд бие даасан тэтгэлгийн нөхцөлтэй байж болно.

8.8 Тус журмын 8.1, 8.2, 8.3, 8.5, 8.6 дахь тэтгэлэг давхардсан тохиолдолд элсэгч аль нэгийг нь сонгоно.

8.9 Элсэгчид олгох тэтгэлэг нь эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрт олгогдох бөгөөд "МУИС-д суралцагчдад тэтгэлэг олгох ерөнхий журам"-аар зохицуулагдана<sup>6</sup>.

### **ЕС. Бакалаврын зэрэгтэй иргэн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэх**

9.1 Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 03 дугаар сарын 18-ны А/79 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам"-ын 7.1 дэх хэсгийг үндэслэн бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй иргэнийг

<sup>6</sup> Хичээлийн жилийн нэг улиралд суралцагчид олгох мөнгөн дүнгийн хэмжээ тухайн хөтөлбөрийн 15 багц цагийн сургалтын төлбөрөөс илүүгүй байна.

бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэлтийн ерөнхий шалгалтгүйгээр элсүүлэн суралцуулж болно.

9.2 Журмын 9.1-д заасан иргэн <https://burtgel.num.edu.mn> хаягийн бүртгэлийн нэгдсэн системээр бүртгүүлнэ. Бүртгэлийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 09:00 цагт нээж, 06 дугаар сарын 02-ны өдрийн 12:00 цагт хаана

9.3 Бүртгүүлэгч нь тус журмын хүснэгт 1-т заасан сонгох боломжтой бакалаврын үндсэн мэргэжлийн хөтөлбөрийн жагсаалтаас сонгон бүртгүүлнэ.

9.4 Бүртгүүлэгч нь элсэлтийн системд шаардлагатай мэдээллийг оруулж элсэх хүсэлт гаргаж, бүртгэлийн хураамжийг төлнө.

9.5 Бүртгүүлэхдээ элсэлтийн систем дэх анкетыг бөглөж, дараах бичиг баримтыг цахим хэлбэрээр хавсаргана. Үүнд:

9.5.1 Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (гадаад паспорт)

9.5.2 Өмнө нь эзэмшсэн бакалаврын боловсролын диплом, хавсралтын хамт (Гадаад хэл дээр бол Монгол хэлээр орчуулан нотариатаар гэрчлүүлсэн байна)

9.5.3 Цээж зураг (Сүүлийн 3 сард авхуулсан, 3х4 хэмжээтэй байх)

9.6 Элсэлтийн комисс тухайн хичээлийн жилийн бакалаврын өдрийн ангид элсэгчдийн Улаанбаатар хотоос хөтөлбөрт элсүүлэх хяналтын тооны 10 хүртэлх хувьд багтаан элсүүлнэ.


9.7 Бүртгүүлэгч, хяналтын тоо, хөтөлбөрийн шаардлагаас хамаарч элсэлтийн комисс шалгалт зохион байгуулж болно.

9.8 Элсэх эрх олгох үйл ажиллагааг 2022 оны 06 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулна.

9.9 Шалгалтад тэнцэж хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч бүрэлдэхүүн/салбар сургуулийн ерөнхий суурь хөтөлбөрийн 1 багц цагийн төлбөрийг төлж элсэх эрхээ баталгаажуулна. Элсэх эрхээ цуцлах тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүй.

9.10 Элсэгч нь 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 17:30 цаг хүртэл <https://burtgel.num.edu.mn> хаягийн бүртгэлийн нэгдсэн системээр нэвтэрч “МУИС-д суралцагч суралцуулах гэрээ”-г зөвшөөрсөн эсэхээ баталгаажуулж, цахим хэлбэрээр бүртгүүлэн оюутан болох хүсэлт илгээн оюутны дугаар, нууц үг авна.

9.11 Хичээл дүйцүүлэхтэй холбоотой асуудлыг “МУИС-д хичээл дүйцүүлэх журам”-аар зохицуулна.





МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/239

Улаанбаатар хот

▮ Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай ▮


МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 4.3.8.4 дэх заалт, Хөтөлбөрийн ерөнхий хорооны 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Их Сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2022 онд оюутан элсүүлэх журам”-ын Хүснэгт 1-ийг хавсралтаар баталж, МУИС-ийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/166 дугаар тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

2. Тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/166 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын Их Сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2022 онд оюутан элсүүлэх журам”-ын Хүснэгт 1-ийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журамд орсон өөрчлөлтийг нийтэд танилцуулах арга хэмжээг зохион байгуулахыг Элсэлт, бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Хишигням)-д үүрэг болгосугай.


ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

1422081855

Захирлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 17 дугаар тушаалын хавсралт



Хүснэгт 1

**Бүрэлдэхүүн/салбар сургуулийн харгалзах суурь болон дагалдах шалгалт, сонгох боломжтой хөтөлбөрийн жагсаалт**

№	Бүрэлдэхүүн /салбар сургууль	Элсэлтийн ерөнхий шалгалт		Сонгох боломжтой бакалаврын үндсэн хөтөлбөр /121 кредит цаг (хэсгийн хувьд 151 кредит цаг)/	Тооцоолсон онооны босго
		“Суурь” шалгалт (70%)	“Дагалдах” шалгалт (30%)		
<b>Бүрэлдэхүүн/салбар сургуулийн багцаар элсэх хөтөлбөрүүд</b>					
<p><i>Бүрэлдэхүүн/салбар сургуулийн багцад элсэгч нь МУИС-ийн “Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам”-ын дагуу нэг жил суралцсаны дараа тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн багцад хамаарах сонгох боломжтой бакалаврын хөтөлбөрөөс сонгон суралцах бөгөөд цуглуулсан багц цаг, сурлагын дүн, анх элсэн ороход тухайн багц, хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрт харгалзах суурь болон дагалдах шалгалтын тооцоолсон оноо өндөр байх тусам хөтөлбөр сонгохдоо давуу эрх эдэлнэ. Түүнчлэн зарим хөтөлбөрийн хувьд бэлтгэж буй мэргэжил, шинжлэх ухааны онцлогоос хамаарч оюутанд хөтөлбөрийн шаардлага тавина.</i></p>					
1	Шинжлэх ухааны сургууль /багц 1/	<ul style="list-style-type: none"> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Монгол хэл</li> <li>• Монголын түүх</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Аялал жуулчлал</li> <li>• Байгаль орчныг зайнаас тандан судлал</li> <li>• Биологийн нөөц судлал</li> <li>• Биохими</li> <li>• Биотехнологи</li> <li>• Газар зохион байгуулалт</li> <li>• Геологи</li> <li>• Геофизик</li> <li>• Хот ба бүс нутгийн төлөвлөлт</li> <li>• Экологи</li> </ul>	480
2	Шинжлэх ухааны сургууль /багц 2/	<ul style="list-style-type: none"> <li>• Математик</li> <li>• Монголын түүх</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> <li>• Англи хэл</li> <li>• Монгол хэл</li> <li>• Орос хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Монгол хэл</li> <li>• Монголын түүх</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> <li>• Орос хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Антропологи</li> <li>• Археологи</li> <li>• Хүн ам зүй</li> <li>• Нийгмийн ажил</li> <li>• Социологи</li> <li>• Сэтгүүлзүй</li> <li>• Сэтгэл судлал</li> <li>• Улс төр судлал</li> <li>• Эдийн засаг</li> <li>• Орон судлал (Араб, Америк, Испани, Итали, Их британи, Польш, Солонгос, Турк, Франц, Хятад, Чех, Япон)</li> </ul>	480

				<ul style="list-style-type: none"> <li>• Гадаад хэлний орчуулга (Англи, Араб, Герман, Орос, Солонгос, Турк, Франц, Хятад, Япон)</li> <li>• Түүх</li> <li>• Урлаг судлал</li> <li>• Утга зохиол судлал</li> <li>• Философи</li> <li>• Хэл, уран зохиол (Монгол, Англи, Хятад, Япон)</li> <li>• Хэл шинжлэл (Монгол, Герман, Орос, Хятад, Япон)</li> <li>• Шашин судлал</li> </ul>	
3	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль /багц 1/	<ul style="list-style-type: none"> <li>• Математик</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Физик</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Компьютерийн ухаан</li> <li>• Мэдээллийн систем</li> <li>• Мэдээллийн технологи</li> <li>• Программ хангамж</li> <li>• Мультимедиа технологи</li> <li>• Статистик</li> <li>• Хэрэглээний математик</li> </ul>	600
4	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль /багц 2/	<ul style="list-style-type: none"> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Материал судлал, инженерчлэл</li> <li>• Нано шинжлэх ухаан, инженерчлэл</li> <li>• Ойн аж ахуй</li> <li>• Ус судлал</li> <li>• Био-инженерчлэл</li> <li>• Химийн инженерчлэл</li> <li>• Хүрээлэн буй орчин судлал</li> <li>• Хүрээлэн буй орчны инженерчлэл</li> <li>• Химийн боловсруулалтын технологи</li> <li>• Цаг уур судлал</li> <li>• Цөмийн инженерчлэл</li> </ul>	480
5	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль /багц 3/	<ul style="list-style-type: none"> <li>• Математик</li> <li>• Физик</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Математик</li> <li>• Физик</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Компьютерийн сүлжээ</li> <li>• Холбооны технологи</li> <li>• Сэргээгдэх эрчим хүч</li> <li>• Электроникийн инженерчлэл</li> </ul>	480

6	Бизнесийн сургууль	• Математик	• Англи хэл • Нийгмийн тухай мэдлэг • Орос хэл	• Банк • Даатгал • Маркетинг • Менежмент • Нягтлан бодох бүртгэл • Санхүү • Худалдаа	600
7	Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	• Англи хэл • Монголын түүх • Орос хэл	• Математик • Монгол хэл • Нийгмийн тухай мэдлэг	• Олон улсын харилцаа • Нийтийн удирдлага	600
8	Эрдэнэт сургууль /багц 1/	• Англи хэл • Орос хэл • Монгол хэл • Математик	• Англи хэл • Биологи • Газар зүй • Математик • Монголын түүх • Монгол хэл • Нийгмийн тухай мэдлэг • Орос хэл • Физик • Хими	• Гадаад хэлний орчуулга (Англи, Хятад, Япон) • Банк • Даатгал • Маркетинг • Менежмент • Нягтлан бодох бүртгэл • Санхүү	410
9	Завхан сургууль	• Англи хэл • Математик • Монгол хэл • Нийгмийн тухай мэдлэг • Физик • Хими	• Англи хэл • Биологи • Газар зүй • Математик • Монголын түүх • Монгол хэл • Нийгмийн тухай мэдлэг • Орос хэл • Физик • Хими	• Банк • Маркетинг • Менежмент • Нягтлан бодох бүртгэл • Санхүү • Худалдаа	410
<b>Бүрэлдэхүүн/салбар сургуулийн шууд сонгон элсэх хөтөлбөрүүд</b>					
№	Бүрэлдэхүүн /салбар сургууль	Элсэлтийн ерөнхий шалгалт		Сонгох боломжтой бакалаврын үндсэн хөтөлбөр /121 кредит цаг (хэсгийн хувьд 151 кредит цаг)/	Тооцоолсон онооны босго
		“Суурь” шалгалт (70%)	“Дагалдах” шалгалт (30%)		
1	Хууль зүйн сургууль	• Нийгмийн тухай мэдлэг	• Математик	• Эрх зүй	600

2	Шинжлэх ухааны сургуулийн байгалийн ухааны хөтөлбөрүүд (багц 3)	<ul style="list-style-type: none"> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Монгол хэл</li> <li>• Монголын түүх</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	
3	Шинжлэх ухааны сургуулийн багш хөтөлбөрүүд (багц 4)	<ul style="list-style-type: none"> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Монгол хэл</li> <li>• Монголын түүх</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш, математикийн боловсрол</li> <li>• Багш, физикийн боловсрол</li> <li>• Багш, химийн боловсрол</li> <li>• Багш, биологийн боловсрол</li> <li>• Багш, газарзүйн боловсрол</li> </ul>	480
4		<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Монгол хэл</li> <li>• Монголын түүх</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> <li>• Орос хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Биологи</li> <li>• Газарзүй</li> <li>• Математик</li> <li>• Монгол хэл</li> <li>• Монголын түүх</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> <li>• Орос хэл</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш, гадаад хэлний боловсрол (Англи)</li> <li>• Багш, гадаад хэлний боловсрол (Орос)</li> <li>• Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол</li> <li>• Багш, нийгмийн ухааны боловсрол</li> </ul>	480
5	Эрдэнэт сургуулийн багш хөтөлбөрүүд (багц 2)	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Орос хэл</li> <li>• Монгол хэл</li> <li>• Математик</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Монголын түүх</li> <li>• Монгол хэл</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> <li>• Орос хэл</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш, гадаад хэлний боловсрол (Англи)</li> <li>• Багш, гадаад хэлний боловсрол (Орос)</li> <li>• Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол</li> <li>• Багш, бага ангийн боловсрол</li> </ul>	410
<b>УБ болон орон нутгийн салбар сургуулийн хамтарсан хөтөлбөрүүд</b> “1+3 хөтөлбөр”, “2+2 хөтөлбөр”-т элссэн суралцагч эхний 1-2 жил орон нутгийн салбар сургууль (Завхан сургууль, Эрдэнэт сургууль)-д “Ерөнхий суурь хичээл”-ийг бүрэн, зарим “Мэргэжлийн суурь”-ийг амжилттай судалж, бусад хичээлийг Улаанбаатар дахь бүрэлдэхүүн сургууль (ОУХНУС, ХШУИС,					Тооцоолсон онооны босго

ШУС-ийн НУС)-д судална. Зарим хөтөлбөрийн хувьд анги бүрдээгүй бол тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн багцад шилжүүлнэ.

№	Хамтарсан бүрэлдэхүүн /салбар сургууль	Элсэлтийн ерөнхий шалгалт		Сонгох боломжтой бакалаврын үндсэн хөтөлбөр /121 кредит цаг (хэсгийн хувьд 151 кредит цаг)/	
		"Суурь" шалгалт (70%)	"Дагалдах" шалгалт (30%)		
1	Эрдэнэт сургууль болон Шинжлэх ухааны сургуулийн хамтарсан 2+2 хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>• Математик</li> <li>• Монголын түүх</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Монгол хэл</li> <li>• Монголын түүх</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сэтгэл судлал</li> </ul>	480
2	Эрдэнэт сургууль болон Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн хамтарсан 2+2 хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Монголын түүх</li> <li>• Орос хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Математик</li> <li>• Монгол хэл</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Олон улсын харилцаа</li> <li>• Нийтийн удирдлага</li> </ul>	600
3	Эрдэнэт сургууль болон Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн хамтарсан 2+2 хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>• Биологи</li> <li>• Математик</li> <li>• Хими</li> <li>• Газар зүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Физик</li> <li>• Математик</li> <li>• Хими</li> <li>• Англи хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүрээлэн буй орчин судлал</li> <li>• Ойн аж ахуй</li> </ul>	480
4	Завхан сургууль болон Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн хамтарсан 2+2 хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Монголын түүх</li> <li>• Орос хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Математик</li> <li>• Монгол хэл</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Нийтийн удирдлага</li> </ul>	600
5	Завхан сургууль болон Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн хамтарсан 1+3 хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>• Биологи</li> <li>• Математик</li> <li>• Хими</li> <li>• Газар зүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Физик</li> <li>• Математик</li> <li>• Хими</li> <li>• Англи хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүрээлэн буй орчин судлал</li> <li>• Ойн аж ахуй</li> </ul>	480

#### Тайлбар:

МУИС-д элссэн оюутан нь өөрийн сонгосон үндсэн хөтөлбөрөөс гадна "Хавсарга хөтөлбөр", "Хос хөтөлбөр"-өөр сонгон суралцах боломжтой. "Хос

хөтөлбөр"-өөр суралцах нь өөрийн суралцаж байгаа үндсэн хөтөлбөрөөс гадна МУИС-ийн бакалаврын хөтөлбөрүүдээс сонгон суралцаж 2 хөтөлбөрийн дипломтой төгсөнө. "Хавсарга хөтөлбөр"-өөр суралцах нь өөрийн суралцаж байгаа үндсэн хөтөлбөрөөс гадна МУИС-ийн бакалаврын аль нэг хөтөлбөрийн хичээлээс сонгон судалж, төгсөхөд тухайн хөтөлбөрийн судалсан хичээлээр дүнгийн хавсралт өгнө.



## Олон улс, улсын олимпиадын нөхцөлөөр элсүүлэх

№	Бүрэлдэхүүн/салбар сургуулийн багц	Олимпиадын чиглэл	Элсүүлэх нөхцөл
1	Шинжлэх ухааны сургууль /багц 1/	<ul style="list-style-type: none"> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	Оролцогч <sup>1</sup>
2	Шинжлэх ухааны сургууль /багц 2/	<ul style="list-style-type: none"> <li>• Математик</li> <li>• Монголын түүх</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> <li>• Англи хэл</li> <li>• Монгол хэл</li> <li>• Орос хэл</li> </ul>	Оролцогч <sup>2</sup>
3	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль /багц 1/	<ul style="list-style-type: none"> <li>• Математик</li> <li>• Мэдээлэл зүй</li> </ul>	1-ээс 3-р байр
4	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль /багц 2/	<ul style="list-style-type: none"> <li>• Биологи</li> <li>• Газар зүй</li> <li>• Математик</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	Оролцогч <sup>7</sup>
5	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль /багц 3/	<ul style="list-style-type: none"> <li>• Математик</li> <li>• Мэдээлэл зүй</li> <li>• Физик</li> </ul>	Оролцогч <sup>7</sup>
6	Бизнесийн сургууль	<ul style="list-style-type: none"> <li>• Математик</li> <li>• Сэтгэх чадвар</li> </ul>	1-ээс 3-р байр
7	Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Монголын түүх</li> <li>• Орос хэл</li> </ul>	1-ээс 3-р байр
8	Эрдэнэт сургууль /багц 1/	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Орос хэл</li> <li>• Монгол хэл</li> <li>• Математик</li> </ul>	Оролцогч <sup>7</sup>
9	Завхан сургууль	<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Математик</li> <li>• Монгол хэл</li> <li>• Нийгмийн тухай мэдлэг</li> <li>• Физик</li> <li>• Хими</li> </ul>	Оролцогч <sup>7</sup>

<sup>1</sup> Улсын олимпиадын төгсгөлийн шатанд оролцсон оролцогчид хамаарна.

<sup>2</sup> Монголын сайхан бичигтэн улсын уралдааны 1-ээс 3-р байрт шалгарсан ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчийг Шинжлэх ухааны сургуулийн Багц 2-т шүүд элсүүлэн суралцуулна.

№	Бүрэлдэхүүн/салбар сургуулийн хөтөлбөр, хамтарсан хөтөлбөр	Олимпиадын чиглэл	Элсүүлэх нөхцөл
1	Хууль зүйн сургууль	• Нийгмийн тухай мэдлэг	1-ээс 3-р байр
2	Шинжлэх ухааны сургуулийн байгалийн ухааны хөтөлбөрүүд (багц 3)	• Биологи • Газар зүй • Математик • Физик • Хими	Оролцогч <sup>7</sup>
3	Шинжлэх ухааны сургуулийн багш хөтөлбөрүүд (багц 4)	• Биологи • Газар зүй • Математик • Физик • Хими	Оролцогч <sup>7</sup>
4		• Англи хэл • Монгол хэл • Монголын түүх • Нийгмийн тухай мэдлэг • Орос хэл	Оролцогч <sup>7</sup>
5	Эрдэнэт сургуулийн багш хөтөлбөрүүд (багц 2)	• Англи хэл • Орос хэл • Монгол хэл • Математик	Оролцогч <sup>7</sup>
6	Эрдэнэт сургууль болон шинжлэх ухааны сургуулийн хамтарсан 2+2 хөтөлбөр	• Математик • Монголын түүх • Нийгмийн тухай мэдлэг	Оролцогч <sup>7</sup>
7	Эрдэнэт сургууль болон олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн хамтарсан 2+2 хөтөлбөр	• Англи хэл • Монголын түүх • Орос хэл	Оролцогч <sup>7</sup>
8	Эрдэнэт сургууль болон хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн хамтарсан 2+2 хөтөлбөр	• Биологи • Математик • Хими • Газар зүй	Оролцогч <sup>7</sup>
9	Завхан сургууль болон Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн хамтарсан 2+2 хөтөлбөр	• Англи хэл • Монголын түүх • Орос хэл	Оролцогч <sup>7</sup>
10	Завхан сургууль болон Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн хамтарсан 1+3 хөтөлбөр	• Биологи • Математик • Хими • Газар зүй	Оролцогч <sup>7</sup>

